



**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар A/08

Улаанбаатар хот

┌
Үүрэг чиглэл өгөх тухай
└

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавьж ажиллах хуваарь", "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлагдсан хуваарийн дагуу нийслэлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт ажиллах албан хаагчдын жижүүрийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Албан хаагчдад халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор халдвар хамгааллын хэрэгслэлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Халдвар хамгааллын хэрэгслэл авахад шаардагдах 98000 /Ерэн найман мянган/ төгрөгийг Бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Нягтлан бодогч /Г.Баярмаа/-д даалгасугай.

4. Хяналтаар ажиллаж буй албан хаагчид худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж буй иргэдийг QR кодоор бүртгүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавьж, зөвлөн тусалж, өдөр бүрийн ажлын тайланг Баянзүрх дүүргийн Онцгой комисст хүргүүлж ажиллахыг Багийн ахлагч нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /С.Туяа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЙОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЦОГТГЭРЭЛ

215030008

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ -ын
даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны
өдрийн 1/28 дугаар тушаалын хавсралт



Халдвар хамгааллын хэрэгслэл авахад шаардагдах
хэрэгслийн жагсаалт

№	Хэрэгслэл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Маск	100	150	15000
2	Бээлий	50 хос	660	33000
3	Шатахууны зардал	10	5000	50000
	Нийт			98000